

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2025/103/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Дундговь аймаг

2025 он

Аудитын газрын дарга,  
Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох  
Утас: 70592439  
Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэл  
Утас: 70592225  
Цахим хаяг: [oyun-erdenet@audit.gov.mn](mailto:oyun-erdenet@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Ихбаяр  
Утас: 70593113  
Цахим хаяг: [Ikhbayard@audit.gov.mn](mailto:Ikhbayard@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит  
ХХК Утас: 77233030  
Цахим хаяг: [info@cptaaudit.mn](mailto:info@cptaaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншаган сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208. Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2025.04.28

№

65

танай

-ны №

**ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН  
ГҮЙЦЭТГЭГЧ А.БИЛЭГСАЙХАН ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2024 оны 04 сарын сарын 01-ээр төрийн албан хаагчийн үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 44.7 хувиар өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 41 хөтөлбөр, арга хэмжээг

4825020225

бүрэн хэрэгжүүлж, аймгийн Боловсролын газартай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 97.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>153,675,807.45</u></b>	<b><u>189,139,316.09</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	55,963,535.01	65,832,850.65
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	55,963,535.01	65,832,850.65
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	55,963,535.01	65,832,850.65
31211	Төрийн сангийн харилцах	54,145,560.60	59,807,156.24
31218	Ахмадын сангийн харилцах	1,817,974.41	6,025,694.41
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	848,500.00	4,718,886.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	750,000.00	2,482,691.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	98,500.00	2,236,195.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	2,236,195.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	96,863,772.44	118,587,579.44
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	39,801,740.58	52,635,363.58
35110	Тусгай зориулалттай материал	39,801,740.58	52,635,363.58
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	57,062,031.86	65,952,215.86
35410	Бичиг хэргийн материал	10,614,370.00	10,984,220.00
35420	Аж ахуйн материал	41,370,671.86	49,153,171.86
35460	Хүнсний материал	5,076,990.00	5,814,824.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,199,413,168.24</u></b>	<b><u>3,453,835,700.24</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,199,413,168.24	3,453,835,700.24
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,154,717,856.28	3,411,540,195.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,078,059,168.25	3,312,423,085.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	(242,188,743.37)	(300,468,122.05)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	70,290,000.00	70,290,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,200,500.09)	(57,134,000.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	346,955,302.95	422,813,212.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(182,178,406.59)	(223,195,972.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	235,358,634.00	297,522,141.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(136,500,830.39)	(158,833,381.19)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	11,000,000.00
39217	Ном	37,123,231.52	37,123,231.52
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	44,695,311.96	42,295,505.04
39301	Програм хангамж	9,379,420.00	9,379,420.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,618,108.04)	(5,017,914.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,934,000.00	37,934,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,353,088,975.69</u></b>	<b><u>3,642,975,016.33</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>18,785,509.53</u></b>	<b><u>58,354,917.35</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	18,785,509.53	58,354,917.35
<b>413</b>	<b>Өглөг</b>	18,785,509.53	58,354,917.35
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	2,441,730.82
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	18,785,509.53	55,863,186.53
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	50,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	50,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,334,303,466.16</u></b>	<b><u>3,584,620,098.98</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,334,303,466.16	3,584,620,098.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	544,254,424.94	544,254,424.94
51101	Өмч: - төрийн	544,254,424.94	544,254,424.94

<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,439,406,575.60	2,689,723,208.42
51210	Өмнөх үеийн үр дүн	2,439,406,575.60	2,444,221,599.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	245,501,609.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	350,642,465.62	350,642,465.62
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,353,088,975.69</u></b>	<b><u>3,642,975,016.33</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**/төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,792,204,236.00</b>	<b>2,565,106,287.20</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>167,545,036.00</b>	<b>358,856,887.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	167,545,036.00	358,856,887.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,663,664.00	312,952,274.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,337,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,337,682.00	28,886,550.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	54,325,982.00	280,728,024.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	102,563,372.00	36,457,690.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,318,000.00	9,446,923.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,624,659,200.00</b>	<b>2,206,249,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,378,912,200.00	1,919,178,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,378,912,200.00	1,919,178,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,026,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,026,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	244,721,000.00	287,070,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	244,721,000.00	287,070,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,737,402,546.71</b>	<b>2,318,474,343.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,737,402,546.71</b>	<b>2,318,474,343.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,681,044,860.56	2,259,115,023.05
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,046,126,510.00	1,513,339,064.00
210101	Үндсэн цалин	745,627,687.00	942,359,447.00
210102	Нэмэгдэл	250,468,224.00	433,402,177.00
210104	Урамшуулал	50,030,599.00	137,577,440.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	129,219,428.50	181,657,870.04
210201	Тэтгэврийн даатгал	88,384,424.50	124,917,810.04
210202	Тэтгэмжийн даатгал	10,370,674.00	14,867,156.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,401,681.00	7,264,522.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,030,997.00	6,159,101.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,031,652.00	28,449,281.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	256,052,398.38	279,656,729.83
210301	Гэрэл, цахилгаан	18,899,488.85	19,007,779.83
210302	Түлш, халаалт	234,022,909.53	259,070,350.00
210303	Цэвэр, бохир ус	3,130,000.00	1,578,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,230,900.00	23,101,950.00
210401	Бичиг хэрэг	1,649,900.00	4,299,610.00
210402	Тээвэр, шатахуун	4,153,600.00	4,390,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	220,000.00	

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,520,900.00	14,411,390.00
210408	Бараа материал акталсны зардал	3,686,500.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>37,894,285.00</b>	<b>36,316,666.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209,300.00	269,600.00
210502	Хоол, хүнс	37,684,985.00	36,047,066.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,505,300.00</b>	<b>7,657,750.00</b>
210604	Урсгал засвар	12,505,300.00	7,657,750.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,998,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	4,998,000.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,688,205.00</b>	<b>24,253,519.94</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,895,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	78,105.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,514,100.00	20,358,519.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>172,329,833.68</b>	<b>193,131,473.24</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,985,350.00	39,894,450.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,919,750.00	6,218,102.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	144,424,733.68	147,018,920.84
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,357,686.15</b>	<b>59,359,320.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,092,575.00</b>	<b>56,293,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,432,785.00	44,399,610.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,659,790.00	11,893,390.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,265,111.15</b>	<b>3,066,320.17</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,265,111.15	3,066,320.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>54,801,689.29</u></b>	<b><u>246,631,943.98</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>1,130,334.59</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,130,334.59
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>(1,130,334.59)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>54,801,689.29</u></b>	<b><u>245,501,609.39</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b><u>1,631,996,882.00</u></b>	<b><u>2,238,623,650.20</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,337,682.00</b>	<b>32,374,250.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,337,682.00	32,374,250.20
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	7,337,682.00	32,374,250.20
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,337,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,337,682.00	29,036,550.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,624,659,200.00</b>	<b>2,206,249,400.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,378,912,200.00	1,919,178,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,378,912,200.00	1,919,178,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,026,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,026,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	244,721,000.00	287,070,500.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	244,721,000.00	287,070,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,570,941,473.50</u></b>	<b><u>2,188,393,184.56</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,570,941,473.50</b>	<b>2,188,393,184.56</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,510,516,722.35</b>	<b>2,131,018,264.39</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,046,286,610.00	1,513,980,126.00
210101	Үндсэн цалин	745,787,787.00	942,656,804.00
210102	Нэмэгдэл	250,468,224.00	433,745,882.00
210104	Урамшуулал	50,030,599.00	137,577,440.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	129,219,428.50	180,547,863.22
210201	Тэтгэврийн даатгал	88,384,424.50	124,267,999.22
210202	Тэтгэмжийн даатгал	10,370,674.00	14,867,156.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,401,681.00	7,264,522.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,030,997.00	6,159,101.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,031,652.00	27,989,085.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	237,266,888.85	279,656,729.83
210301	Гэрэл, цахилгаан	18,899,488.85	19,007,779.83
210302	Түлш, халаалт	215,237,400.00	259,070,350.00
210303	Цэвэр, бохир ус	3,130,000.00	1,578,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	38,072,340.00	36,598,600.00
210502	Хоол, хүнс	38,072,340.00	36,598,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,380,300.00	6,368,350.00
210604	Урсгал засвар	7,380,300.00	6,368,350.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,514,100.00	26,784,492.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,895,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,514,100.00	22,889,492.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	45,777,055.00	87,082,102.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,857,305.00	75,988,550.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,919,750.00	11,093,552.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>60,424,751.15</b>	<b>57,374,920.17</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	59,159,640.00	54,308,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,499,850.00	42,415,210.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,659,790.00	11,893,390.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,265,111.15	3,066,320.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,265,111.15	3,066,320.17
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>61,055,408.50</u></b>	<b><u>50,230,465.64</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>27,629,105.00</b>	<b>40,361,150.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>27,629,105.00</b>	<b>40,361,150.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	27,629,105.00	40,361,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	27,629,105.00	40,361,150.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(27,629,105.00)</u></b>	<b><u>(40,361,150.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	33,426,303.50	9,869,315.64
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	22,537,231.51	55,963,535.01

10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	55,963,535.01	65,832,850.65
----	---	---------------	---------------

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,384,604,886.31	3,279,501,776.87
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,384,604,886.31	3,279,501,776.87
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	54,801,689.29	54,801,689.29
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,439,406,575.60	3,334,303,466.16
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,439,406,575.60	3,334,303,466.16
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	4,815,023.43	4,815,023.43
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,444,221,599.03	3,339,118,489.59
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	245,501,609.39	245,501,609.39
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	544,254,424.94	350,642,465.62	2,689,723,208.42	3,584,620,098.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,283,516,700.00	2,223,895,734.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,283,516,700.00	2,223,895,734.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,222,127,800.00	2,169,587,134.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,537,388,900.00	1,513,980,126.00
210101	Үндсэн цалин	915,148,900.00	933,497,773.00
210102	Нэмэгдэл	560,312,200.00	442,904,913.00
210104	Урамшуулал	61,927,800.00	137,577,440.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	192,173,900.00	180,547,863.22
210201	Тэтгэврийн даатгал	130,678,200.00	124,267,999.22
210202	Тэтгэмжийн даатгал	15,373,900.00	14,867,156.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,687,000.00	7,264,522.00

210204	Ажилгүйдлийн даатгал	7,687,000.00	6,159,101.00
210205	Эрүүл мэндийн даатгал	30,747,800.00	27,989,085.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>281,660,500.00</b>	<b>279,656,729.83</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,000,000.00	19,007,779.83
210302	Түлш, халаалт	259,070,500.00	259,070,350.00
210303	Цэвэр, бохир ус	2,590,000.00	1,578,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>42,890,600.00</b>	<b>36,598,600.00</b>
210502	Хоол, хүнс	42,890,600.00	36,598,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,370,000.00</b>	<b>6,368,350.00</b>
210604	Урсгал засвар	6,370,000.00	6,368,350.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>30,797,400.00</b>	<b>29,533,592.94</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,845,000.00	3,895,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,952,400.00	25,638,592.94
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>130,846,500.00</b>	<b>122,901,872.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,748,900.00	111,808,320.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,097,600.00	11,093,552.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,388,900.00</b>	<b>54,308,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>61,388,900.00</b>	<b>54,308,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,323,000.00	42,415,210.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,065,900.00	11,893,390.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,283,516,700.00</b>	<b>2,229,557,330.03</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,919,178,900.00</b>	<b>1,919,178,900.00</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,919,178,900.00	1,919,178,900.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>287,070,500.00</b>	<b>284,004,179.83</b>
132001	Орон нутгийн төсвөөс	287,070,500.00	284,004,179.83
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>77,267,300.00</b>	<b>26,374,250.20</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	4,287,000.00	3,337,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	23,738,900.00	23,036,550.20
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	49,241,400.00	-
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>54,145,560.60</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>59,807,156.24</b>

**Гурав. Аудитын илрүүлэлт:** /Илрүүлсэн буруу илэрхийллийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 14,169.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 12,416.3 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 282.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,471.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлээ.

**Залруулсан алдаа:**

Аудитаар нийт 12,416.3 мянган төгрөгийн 4 алдаа илрүүлж, аудитын явцад залруулсан. Үүнд

1. ХХОАТ болон НДШ-ийн 172.3 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан
2. Үйл ажиллагааны болон НДШ-ийн зардалд 2,602.8 мянган төгрөгийг дутуу тайлагнасан.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 3,066.3 мянган төгрөгийн тохируулга хийж бүртгэлийн үнэн зөвийг хангаагүй
4. НДШ -ийн тайланд 6,574.8 мянган төгрөгийн ажилчдын цалинг дутуу тайлагнасан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 /үнэн зөв байх/, 20 дугаар зүйлийн 20.2.3 /холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" заасныг зөрчсөн байна. Энэ нь ангилал, үнэн зөв болон үнэлгээ гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Залруулаагүй алдаа:**

Аудитаар нийт 1,753.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 282.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, нийт 1,471.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлжээ.

### **3.1 Төлбөрийн акт**

**3.1.1** Хоолны хөнгөлөлтийн 282.0 мянган төгрөгийг томилолтын зардалтай давхардуулж олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, 16 дугаар зүйлийн 16.5.2-т /батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах зарцуулалтад нь хяналт тавих/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар 13.1. /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.6-д /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна/, 20 дугаар зүйлийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **3.2 Албан шаардлага**

**3.2.1** Нягтлан бодогч, нярвын ажлыг улирал бүр дүгнэж үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 1,471.0 мянган төгрөгийн урамшуулал давхардуулан олгосон. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна”, Засгийн газрын 2023 оны 442-р тогтоолын хавсралтаар өөрчлөлт орсон 2.2 “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна.”, Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалт/ заасныг тус тус зөрчиж, үнэн зөв байх болон эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**3.2.2** Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 25 гүйлгээ буюу 63.4 сая, зарлагын 5 буюу 132.2 сая төгрөгийн гүйлгээг дутуу мэдээлсэн. Энэ нь Шилэн дансны хуулийн хэрэгжилт 77.7 хувьтай, өмнөх аудитаас өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1/мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх/, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 /мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх/, 6 дугаар зүйлийн 6.4.8 /бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр/ заасныг тус тус зөрчиж, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХОАТ болон НДШ-ийн өглөгийг дутуу тайлагнасан.	1	172.3	1	172.3			1	172.3				
Үйл ажиллагааны болон НДШ-ийн зардал дутуу тайлагнасан.	1	2,602.8			1	2,602.8	1	2,602.8				
Төсвийн гүйцэтгэлийн тайланг тохируулга хийж бүртгэлийн үнэн зөвийг хангаагүй	1	3,066.3	1	3,066.3			1	3,066.3				
НДШ -ийн тайланд ажилчдын цалинг дутуу тайлагнасан.	1	6,574.8			1	6,574.8	1	6,574.8				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>12,416.2</b>	<b>2</b>	<b>3,238.6</b>	<b>2</b>	<b>9,177.6</b>	<b>4</b>	<b>12,416.2</b>		-	-	-

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хоолны хөнгөлөлтийг томилолтын зардалтай давхардуулж олгосон.	1	282.0	1	282.0								
Нягтлан бодогч, няравын ажлыг улирал бүр дүгнэж үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч ажлын байрны тодорхойлолтод заагдсан санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв гаргаж, зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр урамшуулал давхардуулан олгосон.	1	1,471.0			1	1,471.0						
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,753.0</b>	<b>1</b>	<b>282.0</b>	<b>1</b>	<b>1,471.0</b>						

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**  
төгрөгөөр/

/мянган

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 25 гүйлгээ буюу 63.4 сая, зарлагын 5 буюу 132.2 сая төгрөгийн гүйлгээг дутуу мэдээлсэн. Шилэн дансны хуулийн хэрэгжилт 77.7 хувьтай, өмнөх аудитаас өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжээгүй	1	-			1	-		
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>	<b>-</b>		<b>-</b>

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			